



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 312

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 3 нэрийн, нийт 56,033,333.00 (тавин зургаан сая гучин гурван мянга гурван зуун гучин гурав) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашиныг данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Л.Бямбасүрэн, Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Л.Ганхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх, бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.2. Хавсралтад заасан автомашиныг засаж сэлбэн, орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, бүртгэх ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Автомашины улсын дугаарыг шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

000552

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн
312 дугаар тогтоолын хавсралт



**ИНЕГ-ын харьяа Газрын үйлчилгээний албаны балансаас хасах
тээврийн хэрэгсэл**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ /төгрөг/	Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/	Үлдэгдэл өртөг /төгрөг/
1	УАЗ-2206 маркийн, 65-80 УНЛ улсын дугаартай, суудлын, арлын дугаар-ХТТ2200АО133312	20011.01	389290	20,200,000.00	20,200,000.00	0.00
2	Starex маркийн, 7406 УБВ улсын дугаартай, суудлын, арлын дугаар-КМJWWN7JP6U698070	2007.08	356690	26,433,333.00	26,433,333.00	0.00
3	Зил-130 маркийн, 06-31 УБК улсын дугаартай, ачааны, арлын дугаар-00020012484591	2003.09	433392	9,400,000.00	9,400,000.00	0.00
	ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН			56,033,333.00 (тавин зургаан сая гучин гурван мянга гурван зуун гучин гурав)	56,033,333.00 (тавин зургаан сая гучин гурван мянга гурван зуун гучин гурав)	